



### НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

#### Жагсаалт, журам батлах тухай

Монгол Улсын "Төсвийн тухай хууль"-ийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, "Эрүүл мэндийн тухай хууль"-ийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.4, 24.5, "Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль"-ийн 21 дүгээр зүйлийн 21.4, 21.5, "Эрүүл мэндийн даатгалын тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.1.5, 13 дугаар үйлийн 13.1.9 дэх заалт, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 28 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/228 дугаар тушаал, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 264/А/293 дугаар тушаал, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн "Дүрэм батлах тухай" А/15 дугаар тушаалаар батлагдсан Өргөө амаржих газрын дүрмийн 2.6.3 заалт, Удирдлагын багийн хурлын 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус амаржих газрын "Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ыг нэгдүгээр, "Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, тариф"-ийг хоёрдугаар, "Нөхцөл сайжруулсан орны тоо, мөрдөх тариф"-ийг гуравдугаар, "ЭМД-ын сангаас санхүүжих өндөр өртөгтэй зарим эмнэлгийн хэрэгсэл, протезийн жагсаалт, түүний даатгалын сангаас санхүүжих хэмжээ, даатгуулагчийн төлөх төлбөрийн тариф"-ийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчдэд чанартай, тэгш, хүртээмжтэй байхаар зохион байгуулж ажиллахыг албадын дарга, тасгийн эрхлэгчид, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга (О.Баянжаргал), Байгууллагын бодлого, төлөвлөлт хариуцсан орлогч дарга (Д.Наранцацралт) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг төсөвт төвлөрүүлэн, биелэлтийг улирал тутам тооцож ажиллахыг Дотоод хяналт, шалгалт хариуцсан ажилтан (Ц.Мөнхцэцэг), Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч (Ч.Гангэрэл) нарт тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Даргын 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/67 тоот тушаал, 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/84 тоот тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцон энэхүү тушаалыг 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.


ДАРГА



А.ДҮҮРЭНБИЛЭГ

3140700389

Нийслэлийн Өргөө амаржих газрын даргын  
2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн  
1/2 тушаалын нэгдүгээр хавсралт



Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар Нийслэлийн Өргөө амаржих газраас үйлчлүүлэгчдэд үзүүлж буй эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулна.
- 1.2. Төлбөртэй тусламж, үйлчилгээ гэдэгт энэхүү журмын хавсралтанд заасан тусламж, үйлчилгээ хамаарах бөгөөд үйлчлүүлэгчид эдгээр тусламж үйлчилгээг авахдаа төлбөр төлнө.
- 1.3. Эрүүл мэндийн даатгалгүй үйлчлүүлэгч тушаалын хоёрдугаар хавсралтад заасан тарифын дагуу төлбөрийг бүрэн төлнө.
- 1.4. Төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг байгууллагын вэб сайт, мэдээллийн самбар, үйлчлүүлэгчийн хүлээлгийн танхим болон байгууллагын кассын дэргэд иргэнд харагдахуйц, ойлгомжтой байдлаар байршуулна.

Хоёр. Төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага, орлого бүртгэх, орлогын зарцуулалт

- 2.1. Төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг амаржих газрын кассаар дамжуулан авч, үндсэн үйл ажиллагааны орлогын бүртгэлд бүртгэн, санхүүгийн програмыг ашиглан төрийн сан дах амаржих газрын төсвийн харилцах дансанд төвлөрүүлнэ.
- 2.2. Үйлчлүүлэгчид төлбөр төлсөн баримт, "E-Barimt"-ыг заавал олгох бөгөөд амаржих газрын нэр, иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.
- 2.3. Төлбөртэй орны төлбөрийг тухайн тасгийн арга зүйч эх баригч, арга зүйч сувилагч хариуцан үйлчлүүлэгчээр байгууллагын кассанд төлүүлэн төлбөрийн баримтын нэг хувийг өвчтний түүхэнд хавсаргана.
- 2.4. Төлбөртэй өрөөнд хэвтэн эмчлүүлснээр үйлчлүүлэгч бусад ижил төрлийн тусламж, үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчээс илүү эмчилгээ, оношлогоо, сувилгаа авах, хөнгөлөлт эдлэх үндэслэл болохгүй.
- 2.5. Үйлчлүүлэгч өөрийн хүсэлтээр төлбөртэй тусламж, үйлчилгээг зогсоох санал гаргавал тухайн тусламж, үйлчилгээг зогсоох хүртлэх үеийн төлбөрийг тооцож, үлдэгдэл төлбөрийг ямар нэгэн шимтгэл, хураамжгүйгээр буцаан олгож баримтжуулна.
- 2.6. Амаржих газрын эмэгтэйчүүдийн тасагт хэвтэж, умайг умайн дайврын хамт бүхэлд нь авах мэс засал хийлгэсэн үйлчлүүлэгч өөрийн хүсэлтээр нугасны гадна хөндийн өвдөлт намдаах эмчилгээг сонгосон бол зөвшөөрлийн маягт бөглөн төлбөрийг мэдээгүйжүүлэгч сувилагч хариуцан үйлчлүүлэгчээр байгууллагын кассанд төлүүлэн төлбөрийн баримтын нэг хувийг өвчтний түүхэнд хавсаргана.
- 2.7. Төлбөртэй тусламж, үйлчилгээний /үр хөндөлт/ орлогын мэдээ, тооцоог нөхөн үржихүйн эрүүл мэндийн кабинетын сувилагч гаргаж, амбулаторийн эрхлэгчээр хянуулах, мөн өвдөлт намдаах эмчилгээний орлогын мэдээ, тооцоог эмэгтэйчүүдийн тасгийн мэдээгүйжүүлэгч сувилагч гаргаж, тасгийн эрхлэгчээр хянуулсны дараа байгууллагын даргаар баталгаажуулж Санхүү, бүртгэлийн албад өгнө.

2.8 Төлбөргүй тусламж, үйлчилгээгээр үр хөндөлт, өвдөлт намдаалт эмчилгээ/олсон орлогын тодорхой хувийг холбогдох тооцооны үндсэн дээр тусламж үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн ажилчдад дараах байдлаар урамшуулал болгон олгоно.

2.8.1 Гар соруурын аргаар үр хөндөлт /унтуулгагүй/ хийж олсон орлогын 20 хувийг үр хөндөлт хийсэн эх барих эмэгтэйнүүдийн эмчид, 3 хувийг сувилагчид, 3 хувийг туслах сувилагчид

2.8.2 Гар соруурын аргаар үр хөндөлт /унтуулгатай/ хийж олсон орлогын 18 хувийг үр хөндөлт хийсэн эх барих эмэгтэйнүүдийн эмчид, 11 хувийг мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний эмчид, 4 хувийг сувилагчид, 4 хувийг туслах сувилагчид

2.8.3 Эмийн аргаар үр хөндөлт хийж олсон орлогын 10 хувийг үр хөндөлт хийсэн эх барих эмэгтэйнүүдийн эмчид, 3 хувийг эх баригчид

2.8.4 Нүгэснү гадна хөндийн өвдөлт намдаах эмчилгээнээс олсон орлогын 10 хувийг мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний эмчид, 3 хувийг мэдээгүйжүүлэгч сувилагчид тус тус олгоно.

Гурав. Эрүүл мэндийн даатгалаар үйлчлэх тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, үйл ажиллагаа

3.1 Тус амаржих газарт зөвхөн эмэгтэйнүүдийн /жирэмсэнтэй холбоотой/ өвчний учир амбулаторид тухайн сард хийгдсэн оношилгоо, шинжилгээг нэг бүлэг болгон, нэг тохиолдол хэмээн бүртгэнэ.

3.2 Оношилгоо, шинжилгээ хийлгэсэн даатгуулагчийн мэдээллийг даатгуулагч бүртэй хийсэн төлбөрийн тооцооны хамт Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүргэнэ.

3.3 Эрүүл мэндийн даатгалгүй иргэн эрүүл мэндийн даатгалаас санхүүждэг бүх төрлийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээний зардлыг өөрөө хариуцаж, төлбөрийг байгууллагын дансанд кассаар дамжуулан тушааж, мөнгө төлсөн баримтын нэг хувийг өөртөө авна.

3.4 Эрүүл мэндийн даатгалгүй иргэд болон тухайн жилд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн дээд хязгаараас хэтэрсэн даатгуулагч өндөр өртөлт мөс заслын нэг удаагийн хэрэгслийн төлбөрийг өөрөө бүрэн хариуцна.

3.5 Даатгуулагч тушаалын дөрөвдүгээр хаасралтад заасан өндөр өртөлт эмнэлгийн хэрэгслийн төлбөрийг байгууллагын кассанд тушаана.

3.6 Амаржих газрын худалдан авах ажиллагааны журмаар нийлүүлэгдээгүй өндөр өртөлтэй зарим эмнэлгийн хэрэгслийг үйлчлүүлэгч өөрөө худалдан авна. Энэ тохиолдолд эмч үйлчлүүлэгчдэд урьдчилан танилцуулж, үйлчлүүлэгч зөвшөөрсөн байна.

3.7 Эрүүл мэндийн даатгалгүй иргэд өндөр өртөлтэй нэг удаагийн хэрэгслийн төлбөрийг өөрөө бүрэн хариуцан худалдан авах ажиллагааны үнийн дүнгээр кассанд тушаана.

Дөрөв. Хориглох зүйл

4.1 Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.1-т "жирэмсэн, төрөлт, төрсний дараах үетэй холбоотой эх барихын тусламж, үйлчилгээний зардал" заасан тусламж, үйлчилгээ авч буй иргэнээс төлбөр авах

4.2 Эрүүл мэндийн даатгалын сангаас оношилгоо, шинжилгээнд ногдож буй зардлыг даатгуулагчаас давхардуулан авахыг хориглоно

4.3 Үйлчлүүлэгчдээс жагсаалтанд зааснаас бусад тусламж, үйлчилгээнд төлбөр авах, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд иргэдтэй шууд төлбөр тооцоо хийх


4.4 Ажлын байрандаа эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, бусад материал хэрэгслийг худалдах

4.5 Иргэдээс нөмрөг, улавч, бие засах газар, өвчтөн шилжүүлэх болон шинжилгээний бичиг олгох, хувцас өлгөх зэрэг нийтлэг үйлчилгээнээс төлбөр авах

#### Тав. Журам зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага

5.1 Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтан, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтануудад Хөдөлмөрийн тухай хууль, амаржих газрын хөдөлмөрийн дотоод журамд заасан арга хэмжээг авч, хохирлыг буруутай этгээдээр төлүүлнэ.

Нийслэлийн Өргөө амаржих газрын даргын  
2020 оны 03 дугаар сарын 18 ний өдрийн  
1/22 тушаалын хоёрдугаар хавсралт



Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, тариф

№	Үйлчилгээний төрөл	Төлбөрийн хэмжээ /төг/
Жирэмсний эрт үеийн үр хөндөлт (12 долоо хоног хүртэлх)		
1	Эмийн аргаар үр хөндөх	50,000
2	Гар соруурын аргаар ажилбар хийх (унтуулгагүй)	75,000
3	Гар соруурын аргаар ажилбар хийх (унтуулгатай)	95,000

Өвдөлт намдаах эмчилгээ

№	Эмчилгээний төрөл	Төлбөрийн хэмжээ /төг/
1	Эпидурал (нугасны өвдөлт намдаалт)	50,000

Оношлогоо, шинжилгээ

№	Шинжилгээний нэр төрөл	Төлбөрийн хэмжээ /төг/	
Лабораторит хийх шинжилгээ			
1	Иммунологийн шинжилгээ	В, С вирус	10,000
		Асло, СРУ, РФ	5,000
2	Бактериологийн шинжилгээ	Үтрээний наац/мазок/	10,000
		Цусны ариун чанарын шинжилгээ	15,000
		Шээсний ариун чанарын шинжилгээ	10,000
		Өтгөний ариун чанарын шинжилгээ	10,000
3	Биохимийн шинжилгээ	Элэгний үйл ажиллагаа	19,800
		Бөөрний үйл ажиллагаа	17,500
		Холестрин	2,500
		Сахар	2,000
		Цусанд электролитүүд /Na, K, CL/	4,000
4	Шээсний шинжилгээ	5,000	
5	Цусны ерөнхий шинжилгээ	5,000	
6	Цусны бүлэг тодорхойлох	2,000	
7	Коагулограммын шинжилгээ	5,000	

Оношлогоо

1	Хэт авиан оношлогоо үтрээ болон хэвийн /жирэмснээс бусад/	15,000
2	Кольпоскопия	60,000
3	Кольпоскопия/ Эсийн шинжилгээ/	30,000
4	Кольпоскопия/ Эдийн шинжилгээ/	35,000
5	Зүрхний цахилгаан бичлэг	5,000
6	Уродинамикийн шинжилгээ	150,000
7	Гистеросальпингографийн шинжилгээ	120,000



Нийслэлийн Өргөө амаржих газрын даргын  
2020 оны 03 дугаар сарын 18 ний өдрийн  
Тушаалын гуравдугаар хавсралт

Нөхцөл сайжруулсан орны тоо, мөрдөх тариф

№	Тасгийн нэр	Орны тоо	Нэг ор хоногийн төлбөр /төг/
1	Эх барих тасаг		
	Жирэмсний эмгэг эмчлэх хэсэг	2	20,000
	Дутуу тээлтийг эмчлэх хэсэг	2	20,000
	Төрөх хэсэг /люкс/	2	50,000
	Төрсний дараах хэсэг	2	20,000
	Мэс засал, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний хэсэг	1	20,000
2	Нярайн тасаг		
	Нярайн эмгэгийг эмчлэх хэсэг /хагас люкс/	1	30,000
3	Эмэгтэйчүүдийн тасаг	2	20,000

Нийслэлийн Өргөө амаржих газрын даргын  
2020 оны 03 дугаар сарын 18 ний өдрийн  
А/З тушаалын дөрөвдүгээр хавсралт

1119287569 9077006

ЭМД-ын сангаас санхүүжих өндөр өртөгтэй зарим эмнэлгийн хэрэгсэл, протезийн жагсаалт, түүний даатгалын сангаас санхүүжих хэмжээ, даатгуулагчийн төлөх төлбөрийн тариф

№	Олон улсын өвчний код (ICD-10)	Өвчний нэр	Хийгдэх мэс засал	Үйлдлийн олон улсын ангилал (ICD9)	Хэрэглэгдэх өндөр үнэтэй мэс заслын багаж хэрэгсэл	Код	Тендерийн үнэ	ЭМД-аас олгох хөнгөлөлт ийн хэмжээ	Даатгуулагчаас гарах төлбөр
1					Дурангийн портууд 10 мм(Трокар) нэг удаагийн	S0244	38 000	28 500	9 500
2	D25-D26, N97, O00, N70, N73, N80-N80.9, N92,	Умайн хүзүүний хорт хавдар, Умайн салстын хорт хавдар, Умайн булчингийн хоргүй хавдар авах, Өндгөвчийн уйланхайт үүсгэвэр, Өндгөвчийн хоргүй хавдар, Гуурсан хоолойн үргүйдэл болон идээт үрэвсэл	Хэвлийн дурангаар умайг бүхэлд нь авах Гуурсан хоолойг нээх, авах, наалдац салгах	68.0-68.9, 66-66.99, 65.3, 65.4, 65.5, 65.6, 68-68.9, 65.01, 65.13, 65.14, 65.21, 65.22, 65.24, 65.31, 65.53, 65.54, 65.61, 65.81, 66, 68.23, 68.2	Дурангийн портууд 5 mm (Трокар)	S0245	38 000	28 500	9 500
3					Угаах, сорох иж бүрдэл	S0381	70 000	52 500	17 500
4	N93, D27, N80-83				Судас болон эдийг түлж тайрах дурангийн гар (Harmonic Laparoscopic Aesclular)	S0236	980 000	735 000	245 000
5					Эрхтэн гаргагч уут	S0079	70 000	52 500	17 500
6	N31, N81	Давсагны унжилт, дарамтат шээс задгайрал	Давсгийг тороор сойх	70.5, 70.9	Давсаг сойх тор	S0262	520 696	390 522	130 174